



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 12.3, 13.3.6, 24.1.14, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн багцын төсөлдөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхландаа тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

ITA1206 9023H034

Засгийн газрын 2024 оны 03 дугаар
сарын 06-ны өдрийн 103 дугаар
тогтоолын хавсралт

**БАГШ, БАГШ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГЧ БОЛОН БАГШ, АЖИЛТНЫ
ХҮҮХДИЙГ ТЭРГҮҮЛЭХ, ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАХАД
ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр суралцагч, багш мэргэжлээр дадлагажигч, орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш болон багш, ажилтны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах нэг хүүхэд (цаашид хамтад нь “багш, суралцагч” гэх)-д төрөөс дэмжлэг (цаашид “дэмжлэг” гэх) үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Багш, суралцагчид төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

1.3. Дэмжлэгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу Боловсролын зээлийн сан (цаашид “сан” гэх)-аас санхүүжүүлнэ.

1.4. Тухайн жил дэмжлэгт хамрагдах багш, суралцагчдын хяналтын тоо, олгох дэмжлэгийн хэмжээг энэ журмын 2.1-д заасан багш, суралцагч тус бүрээр, үргэлжлүүлэн суралцагч бол дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын нэрээр батлагдсан төсвийн хурээнд жил бүрийн I улиралд багтаан боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

1.5. Дэмжлэгт хамрагдах суралцагчдын хяналтын тоо, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, шалгаруулалт, гэрээ байгуулах, холбогдох бусад мэдээллийг сургалтын байгууллагын болон сангийн цахим хуудсаар тухай бүр нээлттэй, ил тод мэдээлнэ.

Хоёр. Багш, суралцагчид тавигдах шаардлага

2.1. Дэмжлэгт дараах багш, суралцагчид хамрагдана:

2.1.1. Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч;

2.1.2. багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч;

2.1.3. боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч;

2.1.4. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч;

2.1.5.Боловсролын ерөнхий хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш;

2.1.6.Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны нэг хүүхэд.

2.2.Энэ журмын 2.1-д заасан багш, суралцагч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.2.1.Монгол Улсын иргэн байх;

2.2.2.холбогдох шалгалтын журмын дагуу элссэн, боловсролын цахим мэдээллийн системд бүртгэгдсэн байх;

2.2.3.Боловсролын ерөнхий хуулийн 12.5, Дээд боловсролын тухай хуулийн 12.12-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх.

2.3.Энэ журмын 2.1-д заасан багш, суралцагч дараах тусгай шаардлагыг хангасан байна:

2.3.1.энэ журмын 2.1.1-д заасан суралцагч ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн хөтөлбөрт суралцаж, багш сонгоны хичээлд амжилттай буюу, 80 болон түүнээс дээш хувиар үнэлэгдэж төгссөн байх;

2.3.2.энэ журмын 2.1.2-т заасан багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрт элссэн суралцагч элсэлтийн шаардлага хангасан, эсхүл үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 2.7-оос доошгүй байх;

2.3.3.энэ журмын 2.1.3-т заасан магистрын сургалтын үндсэн хөтөлбөрийн суралцагч дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексийн ерөнхий чиглэл (01)-ээр суралцахаар сонгосон байх, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.0-оос доошгүй байх, төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад хөдөө орон нутагт 3-аас доошгүй, эсхүл нийслэлд 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.4.энэ журмын 2.1.4-т заасан суралцагч хөдөө орон нутагт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллахдаа 3 болон 4 дүгээр дамжааны суралцагч байх, суралцсан хугацааны голч дүн 2.7 болон түүнээс дээш байх;

2.3.5.энэ журмын 2.1.5-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллаж байгаа багш нь бакалавр, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрт мөрдөх мэргэжлийн чиглэл, индексийн ерөнхий чиглэл (01)-ээр хөрвөн суралцахаар сонгосон байх, аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн сүл орон тоо (үндсэн орон тоо байх)-нд 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан байх;

2.3.6.энэ журмын 2.1.6-д заасан суралцагчийн эцэг, эхийн аль нэг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй багш, ажилтнаар ажилласан байх, төрийн өмчийн сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлээр дэд бакалавр, бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрийг сонгосон байх.

2.4.Багшийн мэргэжлийг 2 дахь мэргэжлээр сонгосон бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч энэ журмын 2.2, 2.3.2-т заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан байна.

2.5.Энэ журмын 2.1.3, 2.1.5-д заасан магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч ажиллахын зэрэгцээ суралцах хөтөлбөрийн төлөвлөлтийг сонгосон байна.

2.6.Энэ журмын 2.1.6-д заасан “ажилтан”-д Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа, Засгийн газраас баталсан албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарах удирдах, гүйцэтгэх, туслах ажилтныг хамруулна.

2.7.Энэ журмын 2.3.5-д заасан сул орон тоог тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сүүлийн 2 хичээлийн жилийн суралцагчийн болон бүлгийн too, сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тогтооно.

Гурав.Багш, суралцагч, сургалтын байгууллага,
сангийн эрх, үүрэг

3.1.Багш, суралцагч дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.дэмжлэг хүссэн өргөдөл гаргах;

3.1.2.сонгон шалгаруулалттай холбогдуулан өргөдөл, гомдол гаргах;

3.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг сан болон сургалтын байгууллагаас шаардах;

3.1.4.энэ журмын 4.1.1-д заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлэх;

3.1.5.гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

3.1.6.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.1.7.суралцагч төгсөөд 21 хоногийн дотор санд бүртгүүлэх, 12 сарын дотор ажилд орох.

3.2.Сургалтын байгууллага дараах эрх, үүрэгтэй:

3.2.1.багш, суралцагчид олгох дэмжлэгийн талаарх тайлбар, нэмэлт мэдээллийг сангаас авах;

3.2.2.тогтоосон хугацаанд дэмжлэгийг шилжүүлэхийг сангаас шаардах;

3.2.3.гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг сан болон багш, суралцагчаас шаардах;

3.2.4.багш, суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналыг санд хүргүүлэх;

3.2.5.багш, суралцагчийн дэмжлэг хүссэн өргөдлийг хүлээн авах, хянах;

3.2.6.хяналтын тоонд багсан багш, суралцагчийн мэдээллийг сангийн системд бүртгэх;

3.2.7.энэ журмын 3.2.6-д заасан багш, суралцагчийн өргөдлийг санд хүргүүлэх;

3.2.8.багш, суралцагчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг тухай бүр сангийн системд шинэчлэн бүртгэх;

3.2.9.багш, суралцагчийн голч дүн болон бусад мэдээллийг дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэх, улирал тутам шинэчлэх;

3.2.10.гэрээний биелэлтийг дүгнэхэд санг мэдээллээр хангах;

3.2.11.санхүүжилтийн зарцуулалтын тайланг тухайн жилийн 6, 12 дугаар сарын сүүлийн долоон хоногт санд хүргүүлэх;

3.2.12.гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.13.энэ журмын 1.5-д заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нээлттэй, ил тод мэдээлэх.

3.3.Сан дараах эрх, үүрэгтэй:

3.3.1.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг багш, суралцагч болон сургалтын байгууллагаас шаардах;

3.3.2.сургалтын байгууллагаас ирүүлсэн дэмжлэг хүссэн багш, суралцагчийн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авах, хянах, шаардлага хангаагүй тохиолдолд хасах;

3.3.3.багш, суралцагчтай гэрээ байгуулах, сунгах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох;

3.3.4.санхүүжилтийг тогтоосон хугацаанд шилжүүлэх;

3.3.5.гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэх, биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

3.3.6.гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан санхүүжилтийг зогсох, сүүтгах, эргэн төлүүлэх;

3.3.7.санхүүжилтийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.3.8.энэ журмын 1.5, 9.2-т заасан мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэх.

Дөрөв.Бүрдүүлэх баримт бичиг

4.1.Багш, суралцагч дараах нийтлэг баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1.өргөдөл;

4.1.2.иргэний үнэмлэхийн хуулбар;

4.1.3.бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрийн элсэн суралцагч бол элсэлтийн шалгалтын батламжийн хуулбар;

4.1.4.магистрын болон хоёр дахь мэргэжлээр бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрийн элсэгч бол өмнөх боловсролын зэргийн дипломын хуулбар;

4.1.5.үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүнгийн хуудас;

4.1.6.сургалтын төлбөрийн нэхэмжлэхийн хуулбар.

4.2.Багш, суралцагч дараах баримт бичгийг нэмэлтээр бүрдүүлнэ:

4.2.1.энэ журмын 2.1.1-д заасан багш мэргэжлийн сонгон бүлгийг төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээр элсэн суралцагч нь багш мэргэжлийн сонгон бүлэгт амжилттай суралцсаныг гэрчлэх батламжийн хуулбар;

4.2.2.энэ журмын 2.1.3-т заасан магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч нь ажилласан жилийг тодорхойлох ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт;

4.2.3.энэ журмын 2.1.4-т заасан багш мэргэжлээр дадлагажигч нь суралцсан хугацааны голч дүнгийн хуудас, дадлагын удирдамж, дадлагажигчаар ажиллах сургуулийн захиалга, сургуулийн тодорхойлолт;

4.2.4.энэ журмын 2.1.6-д заасан суралцагчийн эцэг, эхийн ажилласан жилийг тодорхойлох байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт;

4.2.5.энэ журмын 2.1.5-д заасан багшийн хувьд мөн журмын 2.3.5-д заасан гэрээ.

Тав.Баримт бичгийг хүлээн авах, хянан үзэх

5.1.Багш, суралцагч энэ журмын 4.1-4.2-т заасан баримт бичгийг бүрдүүлж, сургалтын байгууллагад доор дурдсан хугацаанд ирүүлнэ:

5.1.1.багш мэргэжлээр дадлагажигч нь тухайн оны 9-12 дугаар сард;

5.1.2.энэ журмын 5.1.1-д зааснаас бусад суралцагч нь тухайн оны 2 болон 9 дүгээр сард.

5.2.Сургалтын байгууллага шаардлагатай тохиолдолд ирүүлсэн баримт бичгийн талаар нэмэлт тодруулгыг холбогдох байгууллагаас ажлын 5 өдөрт багтаан авч болно.

5.3.Хугацаа хоцорсон баримт бичгийг хүлээн авахгүй.

5.4.Энэ журмын 2.3.3, 2.3.6-д заасан ажилласан хугацааг байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар нотолно.

5.5.Төрөөс дэмжлэг үзүүлэх өргөдлийг хүлээн авах зарыг тухайн сургалтын байгууллага болон сангийн цахим хуудсанд 30 хоногийн турш байршиулна.

5.6.Сургалтын байгууллага багш, суралцагчийн өргөдөл, холбогдох баримт бичгийг ажлын 20 хоногийн дотор хянан үзэж, энэ журмын шаардлага хангаж хяналтын тоонд багтсан багш, суралцагчийн нэрсийг санд хүргүүлж, мэдээллийг нь сангийн системд бүртгэнэ.

5.7.Сан энэ журмын 5.6-д заасны дагуу ирүүлсэн багш, суралцагчийн баримт бичгийг ажлын 10 өдрийн дотор хянаж, шаардлага хангасан багш, суралцагчийн нэрсийг баталгаажуулж, шаардлага хангаагүй бол нэрсийн жагсаалтаас хасна.

Зургаа.Гэрээ байгуулах

6.1.Энэ журмын 5.7-д заасан багш, суралцагчтай сан, сургалтын байгууллага дэмжлэг үзүүлэх талт гэрээ (цаашид “гэрээ” гэх)-г байгуулна.

6.2.Гэрээний хугацааг хичээлийн улирлын үргэлжлэх хугацаагаар тогтоох бөгөөд гэрээнд дараах асуудлын талаар тусгасан байна:

6.2.1.сонгосон мэргэжлээр суралцах;

6.2.2.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж тэгсөх;

6.2.3.багш бэлтгэх бакалавр, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч тэгсөөд төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад орон нутагт 3-аас доошгүй жил, эсхүл нийслэлд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллах;

6.2.4.багш, ажилтны хүүхэд тэгсөөд мэргэжлээрээ 3-аас доошгүй жил тогтвортой ажиллах;

6.2.5.сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд шилжүүлэх;

6.2.6.гэрээг сунгах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох;

6.2.7.багш, суралцагчийн эрх, үүрэг;

6.2.8.бусад.

6.3.Доор дурдсан нөхцөл байдлыг энэ журмын 6.2.2-т заасан хүндэтгэн үзэх шалтгаанд тооцно:

6.3.1.лаборатори болон багажийн шинжилгээгээр эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдож, эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа;

6.3.2.эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнийг асарсан;

6.3.3.хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан, аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон, галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл (усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт) зэрэг.

6.4.Энэ журамд заасан дэмжлэг үзүүлэх гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Долоо.Багш, суралцагчид үзүүлэх дэмжлэг

7.1.Дэмжлэгт энэ журмын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.6-д заасан багш, суралцагчид олгох сургалтын төлбөрийн мөнгөн тусlamж, 2.1.4-т заасан суралцагчид олгох тэтгэлэг тус тус хамаарна.

7.2.Багш, суралцагчид гэрээний дагуу доор дурдсан дэмжлэг олгоно:

7.2.1.энэ журмын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.6-д заасан багш, суралцагчид сургалтын төлбөр;

7.2.2.энэ журмын 2.1.4-т заасан багшаар дадлагажигчид дадлагын хичээлд шаардагдах хэрэглэгдэхүүн, амьжиргааны болон замын зардалд зориулан сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож гурван сар тутамд 1 удаа олгох тэтгэлэг.

7.3.Сан, сургалтын байгууллагаас ирүүлсэн албан ёсны баримтад үндэслэн багш, суралцагчийн сургалтын энэ журмын 7.2.1-д заасан төлбөрийг тухайн байгууллагын дансанд шилжүүлнэ.

7.4.Сан шаардлагатай тохиолдолд сургалтын байгууллагаас нэмэлт тодруулга авч болно.

7.5.Сан энэ журмын 7.2.2-т заасан тэтгэлгийг багш, суралцагчийн дансанд шилжүүлнэ.

7.6.Давтан судлах, эсхүл цуглуулбал зохих багц цагаас илүү сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг багш, суралцагч өөрөө хариуцна.

7.7.Багш, суралцагч дэмжлэгээр үргэлжлүүлэн суралцах тохиолдолд өмнөх улирлын голч дүн нь багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч бол 2.7-оос доошгүй, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч бол 3.0-оос доошгүй, багш, ажилтны хүүхэд бол өмнөх улиралд сонгон судалсан бүх хичээлд амжилттай үнэлэгдсэн байна.

7.8.Энэ журмын 7.2.2-т заасан эхний гурван сарын тэтгэлгийг тухайн дадлага хийж байгаа байгууллагын тодорхойлолт, сүүлийн гурван сарын тэтгэлгийг дадлагын ажил дууссаны дараа тухайн сургалтын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тус тус олгоно. Энэ тодорхойлолтын загварыг сангийн Ажлын албаны дарга батална.

Найм.Гэрээг түдгэлзүүлэх, сунгах,
дуусгавар болгох

8.1.Багш, суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 3 сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон тохиолдолд гэрээг түдгэлзүүлнэ.

8.2.Гэрээг түдгэлзүүлэхэд энэ журмын 8.1-д заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн талууд баримт үйлдэж, гэрээнд хавсаргасан байна.

8.3.Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гэрээ түдгэлзүүлэх хугацаа 1 жилээс хэтрэхгүй бөгөөд түдгэлзүүлсэн хугацаанд дэмжлэг олгохгүй.

8.4.Дараах тохиолдолд гэрээг сунгах бөгөөд гэрээ дүгнэсэн баримт үйлдэж, хавсаргасан байна:

8.4.1.багш, суралцагч энэ журмын 7.7-д заасан дүнгийн шаардлага хангасан байх;

8.4.2.гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

8.5.Дараах үндэслэлээр гэрээ дуусгавар болох бөгөөд сангийн Ажлын албаны даргын шийдвэрээр баталгаажна:

8.5.1.энэ журмын 6.2.3, 6.2.4-т заасны дагуу ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байх;

8.5.2.багш, суралцагч нь нас барсан, нас барсан гэж шүүхээс зарласан, сураггүй алга болсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг холбогдох хууль тогтоомжийн дагуу Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоосон;

8.5.3.аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалсан.

8.6.Энэ журамд заасан “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэснийг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр хөдөлмөрийн чадварыг бүрэн, эсхүл 70 болон түүнээс дээш хувиар алдсан гэж тогтоосныг тооцож үзнэ.

8.7.Энэ журмын 8.5.1-д заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгоход талууд гэрээг үйлдэнэ.

8.8.Энэ журмын 8.5.2-т заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгоход эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэнэ.

8.9.Дараах тохиолдолд энэ журмын 8.5.3-т заасан үндэслэлээр сангийн санаачилгаар гэрээг цуцалж, олгосон дэмжлэгийг буцаан төлүүлнэ:

8.9.1.багш, суралцагч суралцах мэргэжлээ ёөрчилсөн;

8.9.2.багш, суралцагч нь сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чөлөө авсан болон гарсан, чөлөөний хугацааг сунгасан;

8.9.3.багш, суралцагч нь төгсөөд жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 12 сарын хугацаанд ажилд ороогүй, эсхүл гэрээнд заасны дагуу ажиллаагүй;

8.9.4.хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.9.5.суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг шүүхээр тогтоосон.

8.10.Дараах тохиолдолд энэ журмын 8.5.3-т заасан үндэслэлээр сангийн санаачилгаар гэрээг цуцалж, дэмжлэг олгохыг зогсооно:

8.10.1.багш бэлтгэх бакалавр, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагчийн голч дүн 2 удаа тогтоосон шаардлагыг хангаагүй;

8.10.2.багш, ажилтны хүүхдийн дүн энэ журмын 7.7-д заасан шаардлага хангаагүй.

8.11.Энэ журмын 8.10-д заасан дүнгийн шаардлага хангаагүйн улмаас дэмжлэг олгохыг зогсоосон тохиолдолд багш, суралцагч мөн журмын 6.2.3, 6.2.4-т заасан шаардлагыг биелүүлэх бөгөөд биелүүлээгүй тохиолдолд өмнө олгосон дэмжлэгийг хоёр жилийн дотор буцаан төлнө.

Ес.Хяналт, хариуцлага

9.1.Энэ журмын хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

9.2.Сан багш, суралцагч, төгсөгчийн мэдээлэл (суралцагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа, суралцсан улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, сангаас санхүүжүүлсэн зардлын дүн, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл)-ээр сан бурдуулж тухай бүр, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор цахим хуудсаар нээлттэй, ил тод мэдээлнэ. Мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу ашиглана.

9.3.Сан тухайн жилд байгуулсан, түдгэлзүүлсэн, сунгасан, дуусгавар болсон гэрээний мэдээллийг жил бүрийн I улиралд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.4.Сан багш, суралцагчийн мэдээллийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу хадгална.

9.5.Албан хаагч сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих бүхий л үе шатад Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах бөгөөд зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.